



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 298

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 16 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар (Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багц) санхүүжүүлж бий болсон 38 нэрийн, нийт 7,804,501,275.70 (долоон тэрбум найман зуун дөрвөн сая таван зуун нэг мянга хоёр зуун далан таван төгрөг далан мөнгө) төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг хавсралтад заасны дагуу Хөвсгөл, Ховд, Сэлэнгэ аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Хөвсгөл, Ховд, Сэлэнгэ аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө бүртгэлд тусгах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан хөрөнгийг хүлээлцэх, хавсралтад заасан Хөвсгөл, Ховд, Сэлэнгэ аймгийн холбогдох орон нутгийн өмчит байгууллагад эзэмшүүлэх, бүртгэх асуудлыг шийдвэрлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132001610

16-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны ... дугаар сарын ... ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХҮЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН БАГШ) ААР
БИЙ БОЛСОН ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Бүртгэлд тусгах хөрөнгийн нэр, хүчин чадал	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Хөрөнгийн дүн (тегрөг)	Улсын комиссын акт		Бүртгэх байгууллага
						Огноо	Дугаар	
Хөвсгөл аймгийн орон нутгийн өмчид шилжүүлэх								
1	Бизнес хөгжлийн төвийн барилга /Хөвсгөл, Мөрөн/	Конторын барилга /20м х 18м, 1 давхар, зоорьгүй, цутгамал төмөр бетон хийцлэлтэй/	м.кв	360	743,811,452.70	2023.09.11	ББДК-67-38/23	Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газар
2	Бизнес хөгжлийн төвийн барилга /Хөвсгөл, Мөрөн/	Гадна цахилгааны 0.4кв-ын кабель шугам	м	320	56,360,391.00	2023.09.11	ББДК-67-38/23	Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газар
4	Бизнес хөгжлийн төвийн барилга /Хөвсгөл, Мөрөн/	КТПН тоног төхөөрөмж	ш	1	17,277,000.00	2023.09.11	ББДК-67-38/23	Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газар
3	Бизнес хөгжлийн төвийн барилга /Хөвсгөл, Мөрөн/ Дун	Өнгөт хавтан хучилттай явган зам	м	365.8	29,351,157.00	2023.09.11	ББДК-67-38/23	Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газар
6	Бизнес хөгжлийн төвийн өргөтгөлийн барилга /Хөвсгөл, Мөрөн/	Конторын барилга /20м х 18м, 1 давхар, зоорьгүй, 360 м2, цутгамал төмөр бетон хийцлэлтэй/	м.кв	240	590,888,252.00	2023.09.11	ББДК-67-39/23	Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газар
7	Бизнес хөгжлийн төвийн өргөтгөлийн барилга /Хөвсгөл, Мөрөн/	Гадна цахилгааны 0.4кв-ын кабель шугам	м	25	9,822,794.00	2023.09.11	ББДК-67-39/23	Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газар
8	Бизнес хөгжлийн төвийн өргөтгөлийн барилга /Хөвсгөл, Мөрөн/	Өнгөт хавтан хучилттай явган зам	м	72	5,291,590.00	2023.09.11	ББДК-67-39/23	Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газар
9	Бизнес хөгжлийн төвийн өргөтгөлийн барилга /Хөвсгөл, Мөрөн/	Гадна хашаа	м	450	43,837,925.00	2023.09.11	ББДК-67-39/23	Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газар
10	Бизнес хөгжлийн төвийн өргөтгөлийн барилга /Хөвсгөл, Мөрөн/ Дун	Гадна бохир усны шугам /ф 110 мм хоолой, ф 150 мм хоолой, БУХ 1000 мм/	м	22	11,842,646.00	2023.09.11	ББДК-67-39/23	Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газар
11	Хүлэмжийн аж ахуй /Хөвсгөл, Мөрөн сум/	Өвлийн хүлэмж /50*10 хэмжээтэй/	ш	1	661,683,207.00	2023.06.29	220718/05-393	Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газар

12	Хүлэмжийн аж ахуй /Хөвсгөл, Мөрөн сум/	Дулааны зуух	м.кв	600	10,000,000.0	2023.06.29	220718/05-393	Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг даргын тамгын газар
13	Хүлэмжийн аж ахуй /Хөвсгөл, Мөрөн сум/	Гүний худаг /70м/	ш	2	35,000,000.0	2023.06.29	220718/05-393	
14	Хүлэмжийн аж ахуй /Хөвсгөл, Мөрөн сум/	Усны нөөцийн сав	тн	2	1,000,000.0	2023.06.29	220718/05-393	
15	Хүлэмжийн аж ахуй /Хөвсгөл, Мөрөн сум/	Зуны нийлэг хальсан хүлэмж /6*20 хэмжээтэй/	ш	2	21,000,000.0	2023.06.29	220718/05-393	
16	Хүлэмжийн аж ахуй /Хөвсгөл, Мөрөн сум/	Гадна цахилгааны 0.4 кв-ын кабель шугам	м	400	35,000,000.0	2023.06.29	220718/05-393	
17	Хүлэмжийн аж ахуй /Хөвсгөл, Мөрөн сум/	Торон хашаа	м	400	36,000,000.0	2023.06.29	220718/05-393	
18	Хүлэмжийн аж ахуй /Хөвсгөл, Мөрөн сум/	Дуслын усалтын систем	ш	1	800,000.0	2023.06.29	220718/05-393	
	Дүн				400,000,000.0			
Ховд аймгийн орон нутгийн өмчид шилжүүлэх								
19	"Бизнес инкубатор төвийн барилга /Ховд, Булган сум/	Оффисын зориулалттай барилга /зоорьгүй, 3 давхар/ 1447.5 м2 талбайтай барилга,	м.кв	1,447.5	4,371,605,438	2023.12.08	53/2023	Ховд аймгийн Булган сумын ЗДТГ
20	"Бизнес инкубатор төвийн барилга /Ховд, Булган сум/	Хяналтын камер	ш	10	20,186,146	2023.12.08	53/2023	
21	"Бизнес инкубатор төвийн барилга /Ховд, Булган сум/	Явган зам	м.кв	463.6	4,536,664	2023.12.08	53/2023	
22	"Бизнес инкубатор төвийн барилга /Ховд, Булган сум/	Авто бетон зам	м.кв	840.02	122,010,352	2023.12.08	53/2023	
23	"Бизнес инкубатор төвийн барилга /Ховд, Булган сум/	Төмөр хайс /1.2м*3м/	ш	54	9,798,584	2023.12.08	53/2023	
24	"Бизнес инкубатор төвийн барилга /Ховд, Булган сум/	Гадна хашаа	м	162.4	27,857,002	2023.12.08	53/2023	
25	"Бизнес инкубатор төвийн барилга /Ховд, Булган сум/	Хогийн сав	ш	4	906,972	2023.12.08	53/2023	
26	"Бизнес инкубатор төвийн барилга /Ховд, Булган сум/	Сандал	ш	8	2,209,705	2023.12.08	53/2023	
27	"Бизнес инкубатор төвийн барилга /Ховд, Булган сум/	Саравч 2	ш	2	7,491,080	2023.12.08	53/2023	
28	"Бизнес инкубатор төвийн барилга /Ховд, Булган сум/	Гадна гэрэлтүүлэг	ш	13	25,912,648	2023.12.08	53/2023	
	Дүн				4,592,514,591			
Сэлэнгэ аймгийн орон нутгийн өмчид шилжүүлэх								

29	Зоорийн барилга /Сэлэнгэ, Мандал сум/	Төмс, хүнсний ногоо хадгалах механикжсан зоорийн барилга	м.кв	144	381,001,024.00	2023.10.19	ББКД-43-04/23	Сэлэнгэ аймгийн Мандал сумын ЗДТГ
30	Зоорийн барилга /Сэлэнгэ, Мандал сум/	Агаарын хөргөлт, халаалтын сэнс	ш	1	54,800,000.00	2023.10.19	ББКД-43-04/24	
31	Зоорийн барилга /Сэлэнгэ, Мандал сум/	Хөргөлтийн компрессор	ш	2	19,600,000.00	2023.10.19	ББКД-43-04/25	
32	Зоорийн барилга /Сэлэнгэ, Мандал сум/	Нийлэг хальсан зуны хүлэмж	ш	10	43,261,608.00	2023.10.19	ББКД-43-04/26	
	Дүн				498,662,632			
33	"Шинэ хөдөө төсөл"-ийн өвөл, зуны хүлэмжийн барилга /Сэлэнгэ, Баруунбүрэн сум/	Өвлийн хүлэмж	м.кв	420.8	559,103,063.0	2023.11.22	БУ-115/2023	Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын ЗДТГ
34	"Шинэ хөдөө төсөл"-ийн өвөл, зуны хүлэмжийн барилга /Сэлэнгэ, Баруунбүрэн сум/	Төмөр сараалжин хашаа	м	1379	64,634,376.0	2023.11.22	БУ-115/2023	
35	"Шинэ хөдөө төсөл"-ийн өвөл, зуны хүлэмжийн барилга /Сэлэнгэ, Баруунбүрэн сум/	Гадна цахилгааны шугам /АТП 250кВа 10/0.4 кВ 10кВ ЦДАШ/	м	215	86,152,106.0	2023.11.22	БУ-115/2023	
36	"Шинэ хөдөө төсөл"-ийн өвөл, зуны хүлэмжийн барилга /Сэлэнгэ, Баруунбүрэн сум/	Гүний худгийн барилга /12.04 м2/	ш	1	39,532,506.0	2023.11.22	БУ-115/2023	
37	"Шинэ хөдөө төсөл"-ийн өвөл, зуны хүлэмжийн барилга /Сэлэнгэ, Баруунбүрэн сум/	Нийлэг хальсан хүлэмж /2.0х6.0м/	ш	3	26,623,794.0	2023.11.22	БУ-115/2023	
38	"Шинэ хөдөө төсөл"-ийн өвөл, зуны хүлэмжийн барилга /Сэлэнгэ, Баруунбүрэн сум/	Модны дуслын усалгааны систем	ш	1	28,795,000.0	2023.11.22	БУ-115/2023	
	Дүн				804,840,845.0			
	НИЙТ ДҮН				7,804,501,275.7 (Долоон тэрбум найман зуун дөрвөн сая таван зуун нэг мянга хоёр зуун далан таван төгрөг далан мөнгө)			